НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 09 өдөр Дугаар А/817 Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/747 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ачаа тээврийн үйлчилгээг зохицуулан зохион байгуулах, оновчтой тодорхойлох ажлын зайлшгүй шаардлагаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-"Нийтийн тээврийн үйлчилгээний газар"-ын дүрмийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/307 дугаар захирамжаар батлагдсан "Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дүрэм"-ийн 3.2.6, 3.2.7, 3.2.8, 3.2.9, 3.2.10 дахь заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Отгонсүхэд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

11102000386 1

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 09-ны өдрийн
А/219 дугаар захирамжийн хавсралт

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийтийн Тээврийн үйлчилгээний газар (цаашид "Газар" гэх) нь Нийслэлийн хэмжээнд Автотээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, автотээврийн талаар төрөөс баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Автотээврийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдөж ажиллана.

1.3. Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 7.1-т заасан төрийн албанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.4. Газар үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж тайлагнана.

1.5. Газар нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сан банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

2.1. Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.2. Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга, орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга тус тус томилж, чөлөөлнө.

2.3. Газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга батална. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирлаар дүгнүүлнэ.

2.4. Газар нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулахтай холбогдуулан орон тооны бус хяналтын байцаагч ажиллуулж болох бөгөөд орон тооны бус байцаагч ажиллуулах журмыг Нийслэлийн засаг дарга батална.

2.5. Газрын дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.1. батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын тасгийн бодлого, журмын дагуу ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

2.5.2. холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтнуудын цалин хөлс, урамшуулллын хэмжээг тогтоох;

2.5.3. хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх;

2.5.4. архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж удирдах дээд байгууллагын албан тушаалтанд танилцуулах;

2.5.5. газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, ажлын байрны чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд саналаа Нийслэлийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.5.6. сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

2.5.7. ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;

2.5.8. Нийслэлийн Засаг дарга болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гэрээний үндсэн дээр шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.5.9. газрын дарга батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах;

2.5.10. газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;

2.5.11. орлогч дарга болон нэгжийн дарга, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.5.12. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх;

2.5.13. газрын дарга нь олгосон эрх, үүргийн хүрээнд газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр хэлцэл хийх, гэрээ байгуулах, газрыг төлөөлөх зэрэг үйл ажиллагаа явуулна.

2.5.14. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

2.6. Газрын дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Даргын зөвлөл байгуулан ажиллуулж болно. Даргын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

2.7. Газрын дарга, албан хаагчид Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай Нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана.

2.8. Газрын дарга хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллана.

Гурав. Газрын үндсэн чиг үүрэг

3.1. Газар нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. нийтийн зорчигч болон ачаа тээвэрлэлтийн үйлчилгээг нийслэлийн хэмжээнд зохицуулах, зохион байгуулах;

3.1.2. нийтийн зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шуурхай зохицуулалтаар хангах;

3.1.3. автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх;

3.1.4. авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах;

3.1.5. энэхүү дүрмийн 3.1.1-д заасан үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг судлан, хууль, тогтоомж, стандартын шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргаж, шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулах, сунгах, цуцлах;

3.1.6. автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх, тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын биелэлтэд төрийн захиргааны хяналт тавих;

3.1.7. хүн амын нутагшил, байршлын онцлог, нийтийн зорчигч тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгөөр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх;

3.1.8. нийтийн зорчигч тээврийн сүлжээг шинэчлэн зохион байгуулах, үйлчилгээний чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх;

3.1.9. нийтийн тээврийн үйлчилгээний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, соёлд тавих хяналт шалгалтын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэний төлөөлөлтэй хамтарч ажиллах;

3.1.10. автозамын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээгээр холбогдох стандартын шаардлага хангасан хүүхдийн болон ажилчдын автобус зорчуулах зөвшөөрөл олгох;

3.1.11. нийтийн тээврийн үйлчилгээний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн /GPS, ITS/ системд өөрийн бүртгэл хяналтын системийг нэвтрүүлж хяналт тавих;

3.1.12. нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг тооцож, өдөр тутмын шугамын орлогыг төвлөрүүлсэн дүнгээр нь нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад хуваарилж, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.13. нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх, зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

3.1.14.хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхлэх.

3.2. Газар нь дараах зохион байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. нийслэлийн нийтийн зорчигч тээврийн салбарын дунд болон хэтийн зорилт, стратегийн хүрээнд хэрэгжилтийг хангах, иргэдийн зорчих эрэлт, хэрэгцээг тодорхойлж, үр ашигтай сүлжээ бий болгон хөгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

3.2.2. нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг автотээврийн хэрэгсэл ашиглах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

3.2.3. нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.4. нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд дэвшилтэт технологи, тээврийн төрлийг нэвтрүүлэх, тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.2.5. тээврийн үйлчилгээтэй холбогдсон дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч, нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоож, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.2.6. нийслэлийн хэмжээнд тээврийн салбарын үйл ажиллагаа болон бодлого, зорилт, шийдвэрийн хүрээнд гарч буй хууль тогтоомж, эрх зүйн актууд, стандарт, дүрэм, журмыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангуулах;

3.2.7. нийтийн тээврийн үйлчилгээний автобус, троллейбус болон такси үйлчилгээний тээвэрлэлтийн зардал, зорчих үнэ, тарифыг шинэчлэн тогтоох талаар шаардлагатай тооцоо, судалгааг хийж санал боловсруулж танилцуулах;

3.2.8. нийтийн тээврийн салбарт шинэ техник, технологи болон шинэ төрлийн тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлэх, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, дотоодын болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн үндэслэл, судалгааг боловсруулахад оролцох, төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

3.2.9. нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхтэй холбогдсон тооцоо, судалгааг үндэслэн чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, баталгаажуулах, тохижуулах, камержуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хаягжуулах, тэмдэгжүүлэх талаар санал боловсруулж, хэрэгжилтийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.2.10. нийтийн тээврийн эрэлт, хэрэгцээг хангуулах зорилгоор үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, сүлжээ төлөвлөлт, хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эдийн засгийн хэмнэлттэй, шинэ төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх талаар тооцоо, судалгааг хийж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.11. нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, өргөжүүлэх, мэдээллийн программ хангамжийг сайжруулах, төлбөр төлөх системд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

3.2.12. нийтийн тээврийн автобус болон бусад тээврийн хэрэгслийн зогсоолуудын талбайн хэмжээг тогтооход холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, зогсоолын мэдээллийн нэгдсэн санг үүсгэх;

3.2.13. нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын ажил, үйлчилгээний талаар санал, дүгнэлт гаргах;

3.2.14. нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд шалгаж дүгнэлт гаргах, түвшин тогтоох, аттестатчилал, сонгон шалгаруулалт явуулах ажлыг зохион байгуулах;

3.2.15. нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг зохион байгуулалттайгаар тасалдуулсан, хууль бусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

3.2.16. нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээ, шаардлагатай бусад тооцоо, судалгааг нийслэлийн өмчийн оролцоот "Улаанбаатар смарт карт" ХХК болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч бусад аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авах.

3.2.17. нийслэлийн тээврийн салбарыг хөгжүүлэх ачаа тээврийн чиглэлээр бодлогын баримт бичиг болон үйл ажиллагааны урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.18. ачаа тээврийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнах;

3.2.19. ачаа тээврийн талаарх дүрэм, журмын төсөл боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, үр ашигтай сүлжээ бий болгон хөгжүүлэх ажлыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

3.1.20. ачаа тээврийн салбарт аюултай, технологийн болон тусгай ачаа тээврийн зохицуулалтыг төлөвлөж хяналт тавих, ачаа тээврийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах.

3.1.21. нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн зогсоолын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, их болон урсгал засварын нэгдсэн төсөв гаргаж хэрэгжүүлэх.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэхүү дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан албан тушаалтнууд нь газрын эрх бүхий албан тушаалтанд тооцно.

4.3. Эрх бүхий албан тушаалтан нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж өгөх үүрэгтэй.

4.4. Эрх бүхий албан тушаалтан нь санаатайгаар хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас газарт хохирол учирсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

Тав. Бусад зүйл

5.1. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрыг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд Газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

5.2. Энэхүү дүрэмд тусгагдаагүй асуудлыг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

5.3. Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

.....oOo.....